



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

16171-Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Их тогтуу 1 улс/Факс 32-07-34
E-mail: mbs@barilga.gov.mn


2023 - 01 - 05 № 2/2

таяац | цы | т

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА**

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ**

Тус төв нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг хүргүүлж байна.

Хавсралт . хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  **Б.ЭНХБОЛД**



152300041

ТАНИЛЦУУЛГА

Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж 2022 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

Тайлант хугацаанд тус яам нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэд, байгууллагуудын өргөдөл, гомдлыг хүлээн авч хуульд заасан хугацаанд хариу шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа байгууллага, албан тушаалтанд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 173 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг иргэдээс ирүүлснээс 173 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба шийдвэрлэлтийн явц 100% -тай байна.

Нийт ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн дийлэнх хувийг архивын хуулбар авах, ажилд орох, ахмад настны тэтгэмж хүсэх, тодорхойлолт авах, данс андуурсан гүйлгээ, цалин хэлс тэтгэмжтэй холбоотой өргөдлүүд эзэлж байна.

Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бурдуулэн ажилласан.

2022 оны жилийн эцсийн байдлаар Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хамгийн олон хандалттай асуудал

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд
хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлтийн агуулга /хувиар/
/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

| № | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд зэлэх хувь/ | | | | | | |
|--------------------|-------------------------------|---|--------------------|-------------------------|--|-----------------------|--|--------------------|
| 1 | Барилга, хот байгуулалтын яам | <table> <tr> <td align="center">Нийт 173 өргөдлөөс</td> <td align="center">1. Хүсэлт 160 / 92.5% /</td> </tr> <tr> <td></td><td align="center">2. Гомдол 13 / 7.5% /</td> </tr> <tr> <td></td><td align="center">3. Санал 0 / 0 % /</td> </tr> </table> <p>Тус төвийн шуурхай бүрт албан бичиг болон өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг танилцуулж, салбарын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ, ирэх өдрүүдэд хийхээр төлөвлөж буй ажлын талаар танилцуулан, үүрэг даалгаврыг өгч ажиллаж байна. Шийдвэрлэхэд хүндрэлтэй болон ажил нь удаашралтай байгаа, иргэдийн ирүүлсэн санал гомдлын дагуух ажлуудыг газар дээр нь холбогдох албан тушаалтууд очиж ажиллаж шуурхай шийдвэрлэж байна. Албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлэх явцад өргөдөл гомдлын барагдуулалт, иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг харгалзан үзэж үнэлгээнд тусгаж байна.</p> | Нийт 173 өргөдлөөс | 1. Хүсэлт 160 / 92.5% / | | 2. Гомдол 13 / 7.5% / | | 3. Санал 0 / 0 % / |
| Нийт 173 өргөдлөөс | 1. Хүсэлт 160 / 92.5% / | | | | | | | |
| | 2. Гомдол 13 / 7.5% / | | | | | | | |
| | 3. Санал 0 / 0 % / | | | | | | | |

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд
хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал
/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо | Нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | Үүнээс | | Хугацаа боловгуй | Шийдвэрлэлт /% |
|---|---------------------------------|--|---|-------------------------------------|-------------------------------------|---------------------|-------------------|
| | | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | | |
| 1 | “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ | 173 | 173 | 0 | 0 | 0 | 100% |
| | Дүн | 173 | 173 | 0 | 0 | 0 | 100% |

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд
хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт хэлбэрээр
/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

| № | Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс | | | | |
|---|---------------------------------|--|---------|--------------------|-------------------|--------------------|-------|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ | 173 | 173 | 0 | 0 | 0 | 0 |
| | Дүн | 173 | 173 | 0 | 0 | 0 | 0 |

2022 оны жилийн эцсийн байдлаар/ Барилга, хот байгуулалтын яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг барагдуулах талаар хийж хэрэгжүүлсэн талаарх товч мэдээлэл

Тайлант хугацаанд утсаар 9 гомдол ирсэн ба цаг тухай бүр шуурхай ажиллаж иргэдийн гомдлыг барагдуулсан байна. Дэлгэрэнгүйгээр харуулбал:

1. Иргэн Ж.Мягмарсүрэн нь төслийн менежер ба зураг төсөл зохиох зөвлөх үйлчилгээний гэрзэг БХБЯ-тай байгуулан ажилладаг. Гэрзэт ажлын захиалагчийн техникийн хяналтыг манай байгууллагаар хянуулж байгаа ба энэхүү төслийг хянахаар томилогдсон мэргэжилтэнг өөр мэргэжилтнээр солиулах өргөдөл ирүүлсэн байна. Дээрх өргөдлийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж асуудлыг шийдвэрлэсэн болно.
2. Иргэн Ж.Лхагвасүрэн Магадлал хийсэн ажлын хөлс авах өргөдөл гаргасан ба ажлын хэсэг хуралдаж өргөдөл дурдсан асуудлыг шийдвэрлэсэн байна.
3. Иргэн Г.Оргилмаа нь "Үерийн далан /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/-ийн барилгын ажлаас шалтгаалж оршин суугчдад хохирол учирсан тухай гомдол гаргасан ба 2/702 дугаар албан бичгээр хариу өгч асуудлыг шийдвэрлэсэн болно.
4. Иргэн Н.Батцэрэн БХБЯ-д хандан "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын талаар гомдол гаргасан бөгөөд гомдол гаргагч иргэнтэй 2022.04.05-ны өдөр холбогдож тодруулга авах гэсэн боловч өөрт тулгарсан асуудлаа шийдвэрлэсэн өргөдлөө буцаан татан авсан гэх мэдээлэл өгсөн болно.
5. "Герман Монгол Пропертыйз" ХХК-ийн Итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Итгэл барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт хууль бус үндэслэлгүй тул хүчингүй болгох өргөдөл, гомдол гаргасан байна. Өргөдлийн дагуу холбогдож Улсын комисс зохион байгуулах байгууллага болох Хотын стандарт, хяналтын газарт хандахыг зөвлөсөн болно.
6. Иргэн Е.Шинэцэцэг Шинжээчийн төлбөр авах гомдол ирүүлсэн Тус гомдолд 1/822 дугаар албан бичгээр хариу өгч асуудлыг шийдвэрлэсэн байна.
7. Иргэн Г.Уугандож "Жун чан пропеоти" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан эсэх асуудлаар гомдол гаргасан. Тус чиг үүргийг хэрэгжүүлдэггүй тул

холбогдох хууль, хяналтын байгууллагад хандахыг зөвлөн 1/1177 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн болно.

8. Иргэн Д.Ганбат "Соронз корпорейши" ХХК-ийн барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай гомдол 2022.07.04-ний өдөр ирүүлсэн байна. БҮА-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эрх МХЕГ, БХБЯ-нд хадгалагддаг тул холбогдох уг байгууллагуудад хандах тухай өргөдлийн хариуг VII/8-ны өдрийн 1/1944 дугаар албан бичгээр хүргүүлсэн болно.

9. Иргэн Б.Түвшинжаргал СБД, 1 дүгээр хороо, нарны зам гудамж, 89 дүгээр байр, хаягт байрлах барилгын зураг, төсөл, баримт бичигт хийсэн магадлалын нэгтгэсэн дүгнэлт болон экспертуудийн дүгнэлтүүдийг эс зөвшөөрч гомдол гаргасан байна. Зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргасан экспертийн тайлбарыг 1/2375 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн болно.

10. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны 218 дугаар байрны оршин суугчдын төлөөлөл (8 оршин суугч) Энкант хотхоны авто зогсоолын барилгын магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгож өгөх гомдол гаргасан. Тус гомдлын хүлээн авч судлан 2022.08.30-ны өдрийн 1/2401 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

11. "ТЭД" ХХК-ийн захирал А.Эрдэнэ 2022.09.22-ны өдөр "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын ББЗХХ-ийн хяналтын инженер Ж.Хадбаатарт гүйцэтгэл хянан баталгаажуулахтай холбоотой хариуцлага тооцуулах гомдол гаргасан байна. Тус байгууллагын ирүүлсэн гомдлыг хянан, шалгаж нэмэлт тайлбар, нотлох баримт илүүлэх талаар хүссэн боловч холбогдох тайлбр ирүүлээгүй. Тус компанийн зүгээс Цаашид гүйцэтгэл хянан баталгаажуулах албан бичгийг бичиг хэргийн албан ёсоор хүлээлгэн өгч, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу харилцахыг дурдан 2022.10.25-ны өдрийн 1/3136 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.

12. Иргэн Б.Энхтуул 2019-2022 оны "Барилгад хэрэглэгдэх гол нэр төрлийн барилгын материалын үнийн судалгаа"-г үндэслэн Төгс прогресс ХХК-ийн барьж ашиглалтад оруулсан орон сууцны м² тутамд үнэ нэмэгдүүлэн, тагтны хэмжээг ашигтай талбайд оруулан тооцож, нэмэгдүүлсэн талбайн хэмжээг нэмсэн үнээр үржүүлэн тооцох зэрэг нотолгоо болгон ашиглагдах эсэх талаар хуулийн тайлбар гаргуулах гомдол гаргасан байна. Тус гомдолд 2022.11.30-ны өдрийн 2/3629

дугаартай албан бичгээр тус судалгааг нотлох баримтаар үнэлэх эсэх нь тухайн шуухийн эрх хэмжээний асуудал гэдгийг дурдан хариу хүргүүлсэн байна.

13. Иргэн Л.Бат-Өлзий 2022.12.14-ний өдөр гаргасан гомдолд: “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-аас Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар-т явуулсан албан бичгийг үндэслэлгүй хэмээн үзэж засуулах тухай дурдсан байна. Тус иргэн болон холбогдох компанийтай уулзалт зохион байгуулан үл ойлголцлыг нэн даруй арилгасан тул гомдлоо эгүүлэн авсан болно.